


ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР 12 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН


ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС:

Аймгийн хэмжээний 10 багийн заагийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар тогтоолоор батлуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт байгууллагын 2023 оны 01/387 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан.




Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар 01-ний өдрийн ээлжит хорьдугаар хуралдаанаар аймгийн хэмжээний хот суурин газрын суурьшлын бүсийн тэг гортигийг шинэчлэх, газрын нэгдмэл сангийн ангилал шилжүүлэх тухай саналыг 2023 оны 06 дугаар тогтоолоор батлуулсан.

Аймгийн 2024 оны орон нутгийн төсөвт сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотголын төсөв болох 167.2 сая төгрөгийг мөн батлуулан ажилласан байна.



Аймгийн Засаг даргын 2023 оны А/326 тоот захирамжаар Сүмбэр сумын 1, 2 дугаар багт газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний цахим дуудлага худалдааг 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр газрын цахим сайт болох mle.mn сайтын тусламжтайгаар амжилттай зохион байгуулан ажилласан.



GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр бодит агшны хэмжилтийг хийсэн.



1. Аймгийн төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх засварлах ажил:

Ажлын гүйцэтгэл 100 хувь хийгдэж, техникийн комисс ажилласан. Улсын комисс ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.



2. Боржигон чуулгын барилга : Барилгын гадна металл фасадын ажил хийгдэж байна. Фасадын ажил 40 хувьтай байна. Фасадын бараа материал 100 хувь талбайд буусан байна.



3. Наран гэр хорооллын гадна цахилгаан хангамж: ажлын гүйцэтгэл 95 хувьтай байна. Техникийн комисс ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.



3.Халуун усны барилга: Барилгын ажлын гүйцэтгэл 85 хувьтай байна. Улсын комисс ажиллуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



Барилга байгууламжид улсын комисс ажилласан байдал:

Аймгийн төвийн автозам, Тээвэрчдийн ӨЧ-өөс Сүмбэр сумын ЗДТГ хүртэлх авто замын ажилд улсын комисс ажиллаж, дулааны улиралд зарим нэг ажлыг засаж сайжруулах үүрэг даалгавартайгаар байнгын ашиглалтад хүлээн авсан.

